



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 03 сарын 06 өдөр

Дугаар 293

Улаанбаатар хот

Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2, 28 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам”-ын 10, 17 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 102 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өөрийн өмчийн түрээсийн гэрээний үлгэрчилсэн загвар”-т дор дурдсан агуулга бүхий дараах заалтыг нэмсүгэй:

1/6.14 дэх заалт:

6.14.Түрээслэгч нь барьцаа төлбөрийг байршуулсныг гэрчлэх үнэт цаасыг арилжааны банкнаас авч түрээсийн гэрээний хугацаанд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хадгалуулна.

2.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 102 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өөрийн өмчийн түрээсийн гэрээний үлгэрчилсэн загвар”-ын дараах заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/3.3 дахь заалт:

3.3.Иргэн, хуулийн этгээд нь түрээслэгчийн гэрээний үүргийн биелэлтийн баталгаа болгож 1 (нэг) сарын төлбөртэй тэнцэх хэмжээний буюу (.....) төгрөгийг барьцаа болгон арилжааны банкинд энэхүү гэрээний хугацаанд байршуулна.

3.Энэхүү тогтоолыг 2018 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

4.Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээний үлгэрчилсэн загварт өөрчлөлт орсонтой холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай:

4.1.Сонгон шалгаруулалтын зохих эрх зүйн актын дагуу шалгарсан иргэн, хуулийн этгээдтэй шаардлагатай материалын бүрдлийг хангасан тохиолдолд төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээнд өөрчлөлт оруулсан загварын дагуу гэрээг баталгаажуулж байх;


4.2.Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээсээр ашиглаж буй этгээдийн түрээсийн төлбөр болон улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг гэрээний дагуу тухай бүр бүрэн төлүүлэх арга хэмжээ авах.

0002000

5.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ

Хүрэг:
Хяналтын хэлтэс:
Боловсруулсан: